



**Монгол Улсын соёлын биет бус өв, түүнийг
өвлөн уламжлагчийн бүртгэлийг хөтлөх заавар**

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 2 дугаар бүлэгт заасны дагуу соёлын биет бус өв (цаашид СББӨ гэх), түүнийг өвлөн уламжлагчийг Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санд /цаашид СӨУБМС/ бүртгэхэд БСШУ-ны сайдын 2010 оны 541 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Монгол улсын соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэл”-ийг баримтлана.
- 1.2. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, соёлын өвийн бүртгэл-мэдээллийн сан “Монгол Улсын соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэл”-ээ БСШУ-ны сайдын 2009 оны 414 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтын 2.3-т заасан аймаг, нийслэлийн салбар зөвлөлийн үлгэрчилсэн дүрмийн 3.1-т заасны дагуу СӨУБМС-д ирүүлнэ.
- 1.3. Монгол Улсын соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэлийг үнэн зөв хөтлөн шат, шатны бүртгэл-мэдээллийн сан тус бүрд бүртгэлийн хувийг хадгална.

Хоёр. Бүртгэл хөтлөх

- 2.1. **Улсын Бүртгэл Мэдээллийн Сангийн дугаар /УБМС-ийн дугаар/:** Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангаас бичнэ.
- 2.2. **Аймаг, Нийслэлийн БМС-ийн дугаар:** Тухайн аймаг, Нийслэл дэх бүртгэл мэдээллийн сангаас олгох дугаарыг бичнэ.
- 2.3. **Сум дүүргийн БМС-ийн дугаар:** Тухайн сум, дүүргийн бүртгэл мэдээллийн сангаас олгох дугаарыг бичнэ.
- 2.4. **Соёлын биет бус өвийн тухайн илэрхийллийн нэр:** Тухайн өвлөгчийн өвлөсөн СББӨ-ийн илэрхийллийн нэрийг бичнэ.
- 2.5. **Өвлөн уламжлагчийн тухай товч мэдээлэл:** СББӨ, түүний өвлөгчийн ургийн овог, эцэг(эх)-ийн нэр, өөрийн нэр, хүйс, яс үндэс, төрсөн он, сар, өдөр, регистрийн дугаар, үндсэн захиргаа, оршин суугаа хаяг, мэргэжил, боловсрол, эрхэлж буй ажил гэсэн асуулгуудад хариулан бичнэ.
- 2.6. **Гэрэл зураг:** Өвлөн уламжлагчийн 9x12см хэмжээтэй гэрэл зургийг хавсаргана.
- 2.7. **Хуучнаар аль аймаг хошуу:** Тухайн өвлөгчийн үндсэн захиргаа хуучнаар /1923 оноос өмнө/ аль аймаг, хошуу байсныг бичнэ.
- 2.8. **Алдар цол, гавъяа шагнал:** Төрийн шагнал, Засгийн газар болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас олгосон цол, тэмдгийн нэр болон Олон улсын болон үндэсний хэмжээний урлаг, соёлын наадам, уралдаан тэмцээнээс авсан алдар цол, тэмдэг, олгосон он, сар өдөр, үнэмлэхний дугаарыг бичнэ. ,
- 2.9. **Холбоо барих утасны дугаар:** Өвлөн уламжлагчийн гар утас, гэрийн болон ажлын газрын утсыг бичнэ.
- 2.10. **Шилжилт хөдөлгөөн:** Соёлын биет бус өвийн бүртгэлд анх бүртгэгдснээс хойш өөр орон нутагт шилжин сууршсан бол тухайн хаягийг бичнэ.
- 2.11. **Тухайн хүний өвлөсөн биет бус өвийн мэдээлэл:**
- 2.12. **Ангилал:** Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2010 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн баталсан 92 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт дахь “Монгол Улсын биет бус соёлын өвийн Төлөөллийн Үндэсний Бүртгэл”-ийн ерөнхий таван ангилалын алинд нь багтаж байгааг бичих ба хэрэв тэдгээр 5 ангилалд багтаагүй тохиолдолд бусад гэсэн хэсэгт бичнэ.
- 2.13. **Голлох өвийн төрөл:** Өвлөн уламжлагчийн хамгийн сайн эзэмшсэн өвийг “голлох өв” гэсэн хэсэгт бичнэ.

2.14. **Ур чадвар (Онц, сайн, дунд):** Тухайн Өвлөн уламжлагч эзэмшсэн голлох ба дагалдах өвийн ур чадварын түвшинг “онц”, “сайн”, “дунд” гэсэн үнэлгээгээр өөрөө үнэлж зөвлөнө.

2.15. **Дагалдах өвийн төрөл:** Өвлөн уламжлагч нь нэгээр тогтохгүй төрөл зүйлийг эзэмшсэн бол энэ хэсэгт бичнэ.

2.16. **Өвийн тухай мэдээлэл:** Тухайн өвлөн уламжласан өвийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу бичнэ.

2.17. **Өвийн холбогдолтой домог, хууч яриа, түүх:** Уг өвийн гарал үүсэл, түүх, домог, хууч яриа зэрэг түүхэн холбогдолтой мэдээллийг бичнэ.

2.18. **Хэзээ, хэнээс сурсан (хэд дэх үеийн өвлөн уламжлагч):** Хэзээ, хэнээс сурсан /аав, ээж, эмээ, өвөө, элэнц, хуланц, бусад гэх мэт/ хэрэв үе дамжин уламжалж байгаа бол хэд дэх үеийн өвлөн уламжлагч болохоо бичнэ.

2.19. **Холбогдох зан үйл (ямар байдал, ёс журмаар гүйцэтгэдэг):** Өвийн холбогдох зан үйл, хэзээ, ямар байдал, ёс журмаар гүйцэтгэдэг зан үйлийн талаар бичнэ.

2.20. **Тархац:** Өвийн тархсан байдлын талаар бичнэ. /Бусад аймаг, сум, ястан угсаатанд байдаг эсэх гэх мэт/

2.21. **Өвийн онцлог шинж (одоогийн байдал, хамгаалах арга зам):** Өвийн бусдаас ялгарах онцлог шинж болон одоогийн байдал, хамгаалах арга замын талаар бичнэ.

2.22. **Тухайн өвийн хамгаалалтын байдал:**

ЮНЕСКО-гийн түвшинд: Энэ хэсэгт тухайн өв ЮНЕСКО-гийн Яаралтай хамгаалах шаардлагатай, Хүн төрөлхтний үндэсний төлөөллийн бүртгэлд орсон тохиолдолд бүртгэнэ.

Үндэсний түвшинд: Үндэсний төлөөллийн жагсаалтад орсон өв, Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн Монголын билиг авъяастны улсын жагсаалтад орсон эсэх

Орон нутгийн түвшинд: Зөвхөн Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2010 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн баталсан 92 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт дахь “Монгол Улсын биет бус соёлын өвийн Төлөөллийн Үндэсний Бүртгэл”-д ороогүй өвийн талаар бичнэ.

2.23. **Бусад:** Өвийн болон өвлөн уламжлагчийн талаар дээрх асуулгуудад ороогүй нэмэлт мэдээлэл болон сургалт явуулахад нь улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаад, дотоодын туслалцаа төслөөс санхүүжилт үзүүлдэг эсэх

2.24. **Хавсралт материалын тэмдэглэл:** Тухайн бүртгэлд ном зохиол, архивын баримт, уран сайхны болон баримтат кино зэрэг хавсаргасан материалын нэр, он сар /ном зүй/ зэргийг бичнэ.

2.25. **Бүртгэл хийсэн:** Өвлөн уламжлагчийг бүртгэсэн ажилтан, судлаач өөрийн овог нэр, албан тушаал, бүртгэл хийсэн огноог бичнэ.

2.26. **Байгууллага, сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын нэгдсэн (доогуур зур) бүртгэл-мэдээллийн санд хадгалагдаж байгаа гэрэл зураг, негатив хальс, дуу дүрс бичлэгийг хуурцаг, CD/ DVD / BD, архив ном, хэвлэлийн бичиг баримт:** Бүртгэлийг бүрдүүлж байгаа бүртгэл-мэдээллийн сан нь нэрийнхээ доогуураа зурж тодотгоно. Байгууллага, сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд хадгалагдаж байгаа тухайн өвлөн уламжлагчтай холбогдолтой гэрэл зураг, негатив хальс, дуу дүрс бичлэгийг хуурцаг, CD/ DVD / BD, архив, ном, хэвлэлийн бичиг баримт, бусад баримтын “тоо ширхэг”, “хадгаламжийн дугаар” бичигдэнэ. Тухайн бүртгэл-мэдээллийн сан дээрх баримтаа хадгаламжийн нэгж үүсгэсэн хадгалах ба уг хадгаламжийн хаана тухайн дурсгалын тухай материал ямар дугаартай, хэдэн ширхэг байгааг “тоо ширхэг”, “хадгаламжийн дугаар” хэсэгт бичнэ.

2.27. **Бүрдүүлэлт хийсэн:** Овог нэр, албан тушаал болон бүрдүүлэлт хийсэн он сар өдрийг бичнэ.